

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж

**АРИЛЖААНЫ**

**ГИШҮҮНЭЭР**

**ЭЛСЭХ ГАРЫН**

**АВЛАГА**

Хөгжилд Хамтдаа

## АГУУЛГА

Удиртгал	3
Гишүүнээр элсүүлэх үе шат	3
Арилжааны гишүүний шалгуур	4
Арилжааны гишүүний хүлээх үүрэг	5
Бүрдүүлэх баримт бичиг	6
Арилжааны гишүүнчлэлийн шимтгэл хураамж	7
Арилжааны гишүүнээр элсүүлэх шийдвэр гаргах	7
Арилжааны гишүүнээр гэрээ байгуулах	7
Сургалт	7
Биржийн журмууд	8
Холбоо барих	8

## УДИРТГАЛ

Энэхүү гарын авлага нь Биржийн арилжааны гишүүнээр элсэх өргөдөл гаргагчид чиглэл, зөвлөмж өгөх зорилготой болно.

## ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ҮЕ ШАТ



### Арилжааны гишүүний шалгуур хангах

Биржийн холбогдох журамд заасан шалгуурыг хангах шаардлагатай.



### Бичиг баримт бүрдүүлэх

Холбогдох бичиг баримтыг өргөдөл хянах хураамжийн хамт Биржид хүргүүлнэ.



### Арилжааны гишүүнээр элсүүлэх

Бичиг баримтыг Зах зээл үйл ажиллагааны газар хүлээн авч дүгнэлт гарган ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн ажлын 10 хоногт багтаан шийдвэр гаргана.



### Гэрээ байгуулах

ТУЗ-ийн шийдвэр гарсны дараа 2 тал гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна. Элсэлтийн болон жилийн хураамж төлнө.

# АРИЛЖААНЫ ГИШҮҮНИЙ ШАЛГУУР

Биржийн арилжааны гишүүнээр элсэх өргөдөл гаргагч нь дараах шалгуурыг хангасан байх бөгөөд арилжааны гишүүнчлэлтэй байх хугацаанд тогтмол хангаж ажиллана.

Үүнд:

## Ерөнхий шалгуур

- Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх
- Брокер, дилер, андеррайтерийн тусгай зөвшөөрлийн дор хаяж аль 1(нэг)-ийг эзэмшиж байх
- Арилжааны гишүүнээр элсэх өргөдөл гаргахаас өмнөх 1 (нэг) жилийн хугацаанд татан буулгах, дампууруулах тухай шийдвэр эрх бүхий байгууллагаас хүлээн аваагүй байх
- Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хохироох аливаа хэрэг, маргаанд холбогдоогүй байх
- Тооцооны үйлчилгээ үзүүлэх ерөнхий гишүүнийг сонгон гэрээ байгуулах

## Санхүүгийн шалгуур

- Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журамд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн болон бусад санхүүгийн шалгуурыг хангаж байх
- Цэвэр хөрөнгийн дүн брокер, дилерийн эрхтэй гишүүдийн хувьд 300 сая төгрөгөөс доошгүй байх
- Барьцаа, дэнчин байршуулах чадамжтай байх

## АРИЛЖААНЫ ГИШҮҮНИЙ ШАЛГУУР

### Үйл ажиллагааны шалгуур

- Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа гүйцэтгэх санхүүгийн, хүний нөөцийн болон техникийн чадамжтай байх
- Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжлийн ажилтан 5-аас доошгүй байх
- Гүйцэтгэх удирдлага болон биржийн арилжаанд оролцох, зуучлах ажилтнууд нь үнэт цаасны зах зээл, түүнтэй ижил төрлийн салбарт ажиллаж байсан туршлагатай, сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд үнэт цаасны зах зээлд холбогдолтой гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх
- Биржийн арилжаанд оролцоход шаардлагатай техник хангамжтай байх (үйлдлийн систем, интернет, RAM&Hard drive, нэмэлт программууд)
- Брокер, дилерийн үйлчилгээ эрхлэх үндсэн үйл ажиллагааны журам боловсруулж, мөрдөж байх
- Эрсдэлийн удирдлагын журам боловсруулж, мөрдөж байх

## АРИЛЖААНЫ ГИШҮҮНИЙ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

Арилжааны гишүүн нь биржийн арилжааны журамд заасан арилжаанд оролцогчийн холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх үнэт цаасны компани байх бөгөөд дараах нийтлэг үүргийг хүлээнэ. Үүнд:

- Арилжааны гишүүнчлэлийн гэрээ болон Биржийн журмуудад заасан шалгуур, шаардлагуудыг тогтмол биелүүлж ажиллах
- Шимтгэл, хураамжийг холбогдох журам болон нэхэмжлэхэд заасан хугацаанд төлөх Биржид бүртгэлтэй мэдээлэл өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөлтийн талаар биржид тогтмол мэдээлэл хүргүүлж байх
- Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй бүхий л хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах
- Санхүү болон үйл ажиллагааны тайланг улирал тутамд ирүүлэх

## БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

Биржийн арилжааны гишүүнээр элсэх өргөдөл гаргагч нь дараах баримт бичгийг Биржид ирүүлнэ. Үүнд:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар, дүрэмд оруулсан боловч улсын бүртгэлд бүртгэгдээгүй байгаа нэмэлт өөрчлөлт
- Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар
- Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 хүртэл жилийн санхүүгийн тайлан
- Компанийн үйл ажиллагааг зохицуулсан дотоод журам, харилцагчтай байгуулах гэрээний төсөл
- Арилжаанд оролцох эрх авах, эсвэл эрх авсан ажилтны хувьд нууцлалын гэрээ байгуулсан талаар тодорхойлсон албан бичиг
- Хувь нийлүүлэгч болон толгой, охин компанийн тухай мэдээлэл, энэхүү холбоо хамаарлыг нотлох холбогдох баримтуудын хуулбар
- Санхүүгийн баримт бичиг дээр гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар
- Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигч этгээд болон гүйцэтгэх удирдлагын анкет (биржийн маягтаар)
- Гүйцэтгэх захирал болон ажилтнуудын анкет (биржийн маягтаар)
- Арилжааны гишүүнд тавигдах шалгуурыг хангаж буйг нотлох төрийн байгууллагын лавлагаа тодорхойлолт (Татвар, нийгмийн даатгал, улсын бүртгэлийн газар, цагдаагийн тодорхойлолт)
- Бусад баримт бичиг

## АРИЛЖААНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН ШИМТГЭЛ ХУРААМЖ

Хураамжийн нэр	Хэмжээ	Давтамж	
Өргөдөл хянах үйлчилгээний хураамж	500,000₮		
Элсэлтийн хураамж	Энгийн арилжааны гишүүн	8,000,000₮	1 удаа
	Үүсмэл хэрэгслийн арилжааны гишүүн	3,000,000₮	
Жилийн хураамж	1,000,000₮	жилд 1 удаа	
Хяналтын ажиллагааны хураамж	500,000₮	тухай бүр	

## АРИЛЖААНЫ ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ ШИЙДВЭР ГАРГАХ

Биржийн арилжааны гишүүнээр элсэх шалгуур болон өргөдөл, баримт бичигт үндэслэнбүрэн хүлээлгэж өгснөөс хойш ажлын 10 (арван) хоногт багтаан шийдвэр гаргана.

## АРИЛЖААНЫ ГИШҮҮНЭЭР ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

Биржийн ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн арилжааны гишүүнчлэлийн гэрээ байгуулах бөгөөд уг ажлыг Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгж зохион байгуулна.

## СУРГАЛТ

Бирж нь зах зээлийн үйл ажиллагааны оролцогчдооо Арилжааны болон тооцооны гишүүддээ зориулж тогтмол сургалт зохион байгуулдаг.

## БИРЖИЙН ЖУРМУУД

	Журмын нэр	Тайлбар
1	Арилжааны журам	Арилжааны үйл ажиллагааны үндсэн зарчим болон арилжаанд оролцогчдын харилцааг зохицуулна.
2	Бүртгэлийн журам	Бүртгэлийн ажиллагааны үндсэн зарчим, оролцогчид, бүртгэлийн арга хэлбэр, өөрчлөлт болон үнэт цаас гаргагчтай холбоотой харилцааг зохицуулна.
3	Арилжааны гишүүнчлэлийн журам	Арилжаа гишүүнчлэлийн ажиллагааны үндсэн зарчим, элсэх үйл явц болон арилжааны гишүүдтэй холбоотой харилцааг зохицуулна.
4	Тооцооны үйл ажиллагааны журам	Төв клирингийн тооцооны үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж, төлбөр тооцооны оролцогчдын харилцааг зохицуулна .
5	Хяналтын журам	Үнэт цаас гаргагч болон биржийн гишүүн компани хууль тогтоомж дүрэм журам, үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих, хариуцлага тооцохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
6	Шимтгэл, хураамжийн журам	Биржийн үйлчилгээний хураамж шимтгэлтэй холбоотой харилцааг зохицуулна.

## ХОЛБОО БАРИХ

Арилжаа гишүүнчлэлтэй холбоотой асуудал

Гишүүнчлэлийн мэргэжилтэн  
info@ubx.mn

Төлбөр тооцоотой холбоотой асуудал

Клирингийн мэргэжилтэн  
clearing@ubx.mn

Биржийн төлбөр тооцооны нэхэмжлэхтэй холбоотой асуудал

Нягтлан бодогч

Биржээс зохион байгуулж буй үйл ажиллагаатай холбоотой асуудал

Захиргаа, Бизнес хөгжлийн Газар